

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 – 25

1. *Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/*

4 – 25

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 05 дугаар сарын 14-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 09 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

*Томилолттой: Ч.Анар, Э.Бат-Амгалан, Н.Батсүмбэрэл,
Б.Дэлгэрсайхан, Н.Наранбаатар, П.Наранбаяр, Д.Цогтбаатар;
Чөлөөтэй: Р.Эрдэнэбүрэн;*

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Хар тамхитай тэмцэх газрын дарга П.Сандагсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр Л.Энхнасан, Д.Ганбат, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Хар тамхитай тэмцэх газрын дарга П.Сандагсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, О.Алтангэрэл, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5

Бүгд: 17

70.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 56 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
14 цаг 09 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя.

Ирц бүрдсэн байгаа. Очирбатын Амгаланбаатар гишүүн, Батын Батбаатар гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, ХажекБерын Жангабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан нийт 56.0 хувьтайгаар бүрдэж байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал нэг асуудал байгаа.

Байнгын хорооноос тогтоолын төсөл санаачлаад тогтоолын төслийг өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар батлахаар оруулж ирж байна. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Байнгын хорооны хуралдаан эхэлсэн байгаа.

Хэлэлцэх асуудалдаа саналтай гишүүд алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Та бүхэнд.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос оны эхэнд 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисоос үүдэлтэй нийгэмд учирч байгаа аюул занал, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонссон байгаа.

Хууль зүй, дотоод хэргийн яам болоод холбогдох байгууллагын мэдээллийг сонссон.

Мэдээлэлтэй холбогдуулаад Байнгын хорооноос дараах арга хэмжээг авах тогтоолын төслийг боловсруулсан байгаа.

Тогтоолын төслөөр ерөнхийдөө Засгийн газарт чиглэл өгөх 7 зүйл, заалт бүхий тогтоолын төслийг боловсруулсан.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танхимд оруулъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Засгийн газраас оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Та бүхэнд танилцуулъя.

Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Батзориг, Хар тамхитай тэмцэх газрын дарга, цагдаагийн хурандаа П.Сандагсүрэн хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооноос гарах Байнгын хорооны тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа. “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” гээд үндсэн 7 асуудал байгаа. 7 зүйл, заалттай.

Тэгэхээр бид өнөөгийн нөхцөл байдал өөрөө мансууруулах эм болоод сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээ сүүлийн жилүүдэд нэлээн өсөн нэмэгдэж байгаа.

Тэр дундаа хэрэглээн дээр дийлэнх буюу 50 орчим хувь нь 18-аас 25 насны залуучууд байгаа. Энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэлээн нэмэгдэж байгаа. Шинэ төрлийн эргэлт өөрөө нэмэгдэж байна гэж байгаа. Гаднаас болоод дотоодын эргэлт өөрөө нэлээн өсөн нэмэгдэж байгаа.

Тэгэхээр энэ дээр үндэслээд мансууруулах эм болоод сэтгэцэд нөлөөт бодис буюу бид ерөнхийдөө томоор нь томьёолж хэлээд байдаг нь хар тамхи гэж яриад байдаг. Энэ асуудал өөрөө нийгэмд учирч байгаа нэлээн томоохон аюул занал болж байна.

Тэгэхээр энэ төрлийн бодисоос, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс бид бүхний хувьд энэ тогтоолын төслийг Байнгын хорооноос оруулж ирж байна. Үндсэндээ үндэсний аюулгүй байдал болоод, цаашид хүн амын эрүүл мэндэд нэлээн сөрөг нөлөөтэй асуудал болж байгаа учраас энэ дээр Засгийн газарт чиглэл өгөх, хугацаатай үүрэг даалгавартай, 7 зүйл, заалт бүхий тогтоолын төслийг боловсруулж оруулж ирсэн байгаа.

Гишүүд бид бүхэн хаалттай хуралдаан дээр мэдээллүүдийг сонсоод гишүүдээс тодорхой санал, зөвлөмжүүдийг авсан.

Эдгээрийг үндэслээд 7 зүйл, заалт байгаа.

1 дүгээр заалт үндсэндээ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа шуурхай боловсруулж Улсын Их Хуралд оруулж ир гэсэн чиглэлийг өгч байгаа.

Ерөнхийдөө Хууль зүйн яаман дээр энэ чиглэлийн судалгаа болоод хууль тогтоомжийн төслүүд бэлэн болсон байна гэж ойлгосон. Үүнийг шуурхай оруулж ирэх асуудал номер нэг асуудал байна.

1, 2 дугаар заалт үндсэндээ бодлогын асуудал байгаа.

2 дахь асуудал дээр гол үндсэн асуудал, бид бүхний зорьж байгаа зүйл маань яг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхдээ, урьдчилан сэргийлэхтэй холбогдуулаад үндэсний стратеги төлөвлөлт бид бүхэнд шаардлагатай байна Үүнийг боловсруулж танилцуулж, оруулж ир гэдэг асуудлыг 2 дахь дээр оруулж ирж байгаа. Бодлогын түвшинд.

Энэ бодлогыг гаргахаас өмнө номер нэг онцгой анхаарах ёстой асуудал бол энэ өөрөө юу юм бэ гэхээр бид бүхний хувьд аливаа бодлого, шийдвэр юмнууд маань судалгаан дээр суурилсан байх ёстой байна.

Тэгэхээр мансууруулах эм болоод сэтгэцэд нөлөөлөх бодисын өнөөгийн нөхцөл байдал маань өөрөө ямар байгаа юм, хэрэглэгчийн нарийвчилсан тандалт судалгааг нэгдүгээрт хий гэдэг асуудлыг 2 дугаар зүйл, заалтаар гаргаж ирж байгаа шүү.

Тэгэхээр судалгаан дээрээ суурилж байж үндэснийхээ стратеги төлөвлөлтийг хийх нь байна. Цаашид хийгдэх бодлогын өөрчлөлтүүд болоод шинэчлэлтүүдийг хийх ёстой юм байна гэсэн асуудлыг оруулж ирж байгаа юм.

Тэр дотроо бид чиглэл болгож байгаа зүйл маань хэрэглээтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын тогтолцоо, улс дамнасан зохион байгуулалттай

гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны олон улс улсын сайн туршлагыг судал гэдэг асуудлыг чиглэл болгож гаргаж ирж байгаа.

Дээрээс нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, техник технологи, хүний нөөцийн чадавх, эдийн засаг, нийгмийн баталгааны асуудлыг нь цогцоор нь шийдвэрлэх ийм үндэстний стратеги төлөвлөлтийг боловсруулаад, танилцуулаад тэгээд үүнийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлбэ гэдэг асуудал орж ирж байгаа.

3 дахь, 4 дэх асуудлыг Та бүхэнд онцолж хэлэхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотойгоор, энэ чиглэлийн эргэлт, хэрэглээтэй холбоотойгоор холбогдох байгууллагуудаас мэдээлэл авахад дотоодын эргэлт голлох, дийлэнх хувийг эзэлж байна.

Тэр дотроо бид бүхний яриад байгаа энэ асуудал маань дотоодын эргэлт дотроо жортой, жоргүй эмийн асуудлууд хамгийн гол асуудал болж байна. бид мансууруулах бодис гэж яриад байдаг жоргүйгээр хууль ёсны эмийн эргэлт буюу хууль ёсны эмийн хэрэглээ өөрөө дотоодод нэлээн өндөр болсон байна.

Тэгэхээр бид хяналтдаа авах зайлшгүй шаардлагатай байна.

Тэгэхээр үүнийг мэдээж дотоод, гадаад жагсаалтын асуудал байгаа юм. Жагсаалт. Жагсаалт гэдэг маань нэг талдаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эмийн жагсаалт болоод бодисын жагсаалтыг нэгдүгээрт гаргаж ирж, үүнийгээ тогтмол шинэчилж, үүнийгээ бүртгэлжүүлж, үүнийгээ хяналтдаа авах зайлшгүй шаардлага байна гэдэг асуудлыг 3 дээр оруулж ирж байгаа.

Хоёрдугаарт, дотоодынхоо жагсаалтыг гадаад жагсаалт буюу Монгол Улсын олон улсын гэрээний жагсаалтад ороогүй тэр жагсаалтад нэгтгэж бүртгүүлэх, НҮБ-д мэдээлэх, конвенцод үүнийг тусгуулах асуудлуудыг анхаарч үзээчээ гэсэн асуудал байгаа юм.

Тэгэхээр 3, 4 дэх асуудал дотоод дотоод хяналтыг сайжруулах, эмийн хэрэглээг хязгаарлах, дээрээс нь энэ чиглэлээр бид нэлээн анхаарч үзэж, жортой жоргүйгээр олгож байгаа эмийн хяналтыг сайжруулж, цахим бүртгэлийн хэлбэрт оруулах, эмийн жорын маягт, бүртгэлийг нэлээн бүртгэлжүүлэх шаардлага байна. Шаардлагатай тохиолдол стандарт дээр өөрчлөлт оруул гэсэн асуудлыг гаргаж ирж байгаа.

5 дахь зүйл, заалт дээр бид энэ асуудлыг нэлээн өөр түвшинд гаргаж ирж авч харахгүй бол болохгүй болсон байна. Энэ өөрөө юу юм бэ гэхээр бид нэг талдаа үүнийг гэмт хэрэгтэн, энэ төрлийн эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээд, донтогч гэдэг байдлаар харах биш. Энэ асуудлыг бид нэг талдаа хүнээ хамгаалах бодлого, сэргээн засах, тухайн төрлийн мансууруулах эмд донтсон

донтогчийг, хэрэглэгчийг хамгаалах, сэргээн засах ажил бодлогын түвшинд байх ёстой байх.

Тэгэхээр энэ үүднээс эрүүл мэнд, нийгмийн амь хамгааллын тусламж, үйлчилгээний тогтолцоог бид шинээр бий болгох зайлшгүй шаардлагатай байна гэж харж байгаа.

Бид хүүхэд, залуучуудаа энэ төрлийн, мансууруулах эм, сэтгэц нөлөөлөх бодисоос хамгаалах асуудал хамгаалах зайлшгүй шаардлагатай байна. Сэргийлэх асуудал байх шиг байна.

Тэгэхээр бид энэ төрлийн эргэлтийг бууруулахад буюу энэ төрлийн худалдаа наймааг бууруулахын тулд заавал ч үгүй урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хяналт тавих тогтолцоо өөрөө сайжрах нь үр дүнтэй байна гэж харж байгаа.

Тэгэхээр бид хүнтэйгээ илүү ажиллах, эрүүл мэнд, нийгэм хамгааллын тусламж, үйлчилгээний тогтолцоог бий болгох, эдгээр хүмүүстэй хамааралтай гэдэг юм уу. Тийм ээ. Хэрэглэсэн, донтогч энэ төрлийн хүмүүсүүдэд мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, дээрээс нь үзлэг оношилгоо хийгээд, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг, ухуулга нөлөөлөл хийдэг, магадгүй цаашлаад нийгмийнх нь халамжийн бодлоготой уялдуулж эргээд юу гэдэг юм хөшүүрэг болгож ашиглаж энэ талаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаг байх. Энэ цогц тогтолцоо бид нарт хэрэгтэй байна гэдэг асуудлыг гаргаж ирж тавьж байгаа.

Зургаа дахь асуудал. Мансууруулах эм болоод сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, учирч болох үр дагаврыг нийгэмд ойлгон таниулж, хүүхэд залуучуудад урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга зүй, хөтөлбөрийг тухайн тэр насных нь онцлогт нь нийцүүлж, мөн дээрээс нь эцэг, эхчүүдэд нь тохируулж боловсруулаад мэргэжлийн сургагч багш нарыг бэлтгэж гаргаж ирж хэрэгжүүлдэг байх шаардлагатай байна гэж харж байгаа.

Зөвхөн зүгээр боловсролын хөтөлбөр, сургалтын хөтөлбөр энэ биш. Энэ бол тухайн насны онцлогт нийцсэн эцэг, эхчүүдэд нь тохируулсан мэргэжлийн сургагч багш нар, эцэг эхчүүд болоод хүүхэд, залуучуудтай аж ажиллах бодлогыг гаргаж ирье гэдэг асуудал байгаа. Үүгээрээ дамжуулж бид илүү урьдчилан сэргийлэх, хяналт тавих тогтолцоогоо сайжруулж, эцэг эхчүүдээр дамжуулж эргэлт хэрэглээг бууруулах бодлого зайлшгүй байх ёстой юм байна гэж үзэж байгаа.

Долоо дахь асуудал. Үүнийг манай мэргэжлийн байгууллагууд нэлээн онцолж бид нарт хүсэлт тавьсан асуудал байна.

Тэгэхээр энэ төрлийн дотоодод ургаж байгаа, байгальд ургадаг мансууруулах үйлчилгээ бүхий ургамлын тархцыг нэгдүгээрт нарийвчлан тогтоох, тодорхойлох зайлшгүй шаардлага байна. Үүнд мэргэжлийн байгууллагуудын оролцоо зайлшгүй шаардлагатай байна. Орон нутаг, хувийн хэвшлийн оролцоонд тулгуурласан ургамлын тархцыг нь тодорхойлох, нарийвчлан тогтоох асуудал нэгдүгээр асуудал байх нь байна.

Хоёрдугаарт, гол тавьж байгаа зүйл бол зөвхөн устгалын ажил дээр. Канибас буюу олсны ургамал, марихуан гэж нэрлэгддэг ургамлийг манайд ургаж байгаа, байгальд ургаж байгаа, зэрлэгээр ургаж байгаа ургамлын устгалыг оновчтой болгохын тулд бид зөвхөн цагдаагийн байгууллага, Хууль зүйн яам маань асуудалтай тэмцдэг биш, энэ бүх талын оролцоо байх ёстой. Тэгээд би энэ дээр заалт заалт зааж өгсөн зүйл бол устгалын ажлыг оновчтой үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг ав гэдэг асуудлыг тавьж байгаа юм.

Тэгэхээр Хар тамхитай тэмцэх Үндэсний зөвлөл, хороон дээр энэ асуудлаар бүх талын оролцоог хангах, орон нутаг, удирдлагууд, аймаг, дүүргийн Засаг дарга нар, мэргэжлийн байгууллагууд, магадгүй тэр ургамал судлалын хүрээлэнгүүд гэдэг юм уу. Тийм ээ. Дээрээс нь магадгүй газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд, хувийн хэвшлийн оролцоон дээр тулгуурлаж үүнийг үндэсний хэмжээний арга хэмжээ, үр дүнтэй удирдлага, зохион байгуулалтын бодлого болгож гаргаж ирж хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн ийм 7 зүйл, заалт бүхий бодлогыг оруулж ирж байгаа гэдгийг Та бүхэндээ товчхон танилцуулах шаардлагатай байна.

Ингээд энэ тогтоол хэрэв өнөөдөр Байнгын хороогоор хэлэлцэгдээд, Байнгын хорооны гишүүдийн дэмжлэг аваад батлагдах тохиолдолд Байнгын хорооноос цаашид авах арга хэмжээтэй холбогдуулаад бас нэг зүйлийг төлөвлөж байгаа зүйл маань ирэх долоо хоногийн нэг дэх өдөр Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай Байнгын хорооны гишүүд очиж танилцах шаардлагууд байна гэж харж байгаа.

Одоогийн ажиллаж байгаа бүтэц, орон тоо, чадавхыг нь, цаашид энэ байгууллагын албан хаагч нар тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог нь бүрдүүлэх. Мөн дээрээс нь юу гэдэг юм хэрэглэж байгаа техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл гэдэг юм уу. Мөн энэ байгууллагын мэргэжлийн хүмүүсийн санаа оноо, санал шүүмж, засаглал, тогтолцоог бид нэг яаж олон улсын жишигт нийцсэн бүтэц, зохион байгуулалттай сайн туршлага дээр суурилж илүү өөрчлөлтийг хийх вэ гэдэг асуудлууд дээр очиж ярилцъя гэсэн энэ төлөвлөгөө байгаа. Ирэх долоо хоногийн нэг дэх өдөр.

Хоёрдугаарт, холбогдох энэ байгууллага дээр очиж танилцсаны үндсэн дээр, газар дээр нь очиж мэргэжлийн ажилчид, албан хаагч нартай уулзаж учирсны үндсэн дээр бид цаашид саяын нэг, хоёрдугаар асуудалтай

холбоотойгоор ажлын хэсэг гаргаж, хууль, эрх зүйн орчин, засаглал тогтолцоотой холбоотойгоор ер нь Байнгын хорооноос давхар Засгийн газар хуулийнхаа төслийг оруулж ирэх энэ хугацаанд тогтолцооны өөрчлөлтийг хийх, магадгүй цаашид шаардлагатай үндэсний стратеги, төлөвлөлтийг боловсруулж байх хугацаанд Улсын Их Хурал холбогдох Байнгын хороо буюу манай мэргэжлийн Байнгын хороо энэ дээр ажлын хэсэг гаргаж ажиллая.

Ингээд шуурхай арга хэмжээ авч, магадгүй энэ 8, 9 сар гэхэд Байнгын хороо Улсын Их Хуралд холбогдох бодлогын төслүүдийг оруулж ирээд батлаад ингээд өөрчлөлтүүдийг хийгээд, шаардлагатай төсөв мөнгө, хөрөнгө оруулалтын асуудлуудыг ирэх оны төсөв дээр шийдвэрлээд явъя гэсэн ийм төлөвлөгөөтэй байгааг Та бүхэндээ танилцуулах байна.

Та бүхэнд Байнгын хорооны тогтоолын төслийг ерөнхийд нь агуулгаар нь танилцууллаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Байнгын хорооны хуралдаан өнөөдөр нээлттэйгээр явж байгаа гэдгийг Та бүхэндээ хэлэх байна.

Гишүүдийн нэрсийг авъя. Гишүүд нэрсээ өгөөрэй. Асуулт асуух, санал гаргах гишүүд байна уу? Төхөөрөмж ажиллаж байна уу? Ажиллахгүй байх шиг байна. 4 гишүүн байна. С.Эрдэнэболд гишүүн, О.Алтангэрэл гишүүн, Л.Энхнасан гишүүн, Ж.Энхбаяр сайд гээд. Д.Ганбат гишүүн. Хүсэлт тавьсан. Асуулт асуух, санал гаргах. Ингээд 5 гишүүн байна гэж ойлголоо шүү. Тийм ээ. Д.Ганбат гишүүн. Болсон. Тийм ээ. Тасаллаа.

С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Тэгээд манай Байнгын хорооны дарга хэдэн өдрийн өмнө өгөөд. Энэ дээр өмнөх хэлэлцсэн хэлэлцүүлэг дээр чинь их олон санаанууд байсан. Түүнээс зарчмын хувьд нэлээн сайжирч өөрчлөгдөөд орж ирж байгаа.

Тэгээд өнөөдрийн хурлаас өмнө саналууд авсан. Энэ дээр хоёр, гурван зүйл байгаа.

Нэгд нь, тэр эмчлэх болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үйлчилгээний тогтолцоо бий болгох гэж байгаа. Тэгээд яг энэ маш чухал байгаа юм. Үүнийг зөвхөн Эрүүл мэндийн яам ч юм уу дангаараа хийх боломжгүй юм билээ. Одоо жишээ татахад хорих ангид ял эдэлж байгаа залуучуудын дунд хар тамхи, мансууруулах бодис ч гэх юм уу, сэтгэцэд нөлөөлдөг эм, бэлдмэл хэрэглээд донтсон. Тэгээд эмчилгээний зардал байхгүй. Тэгээд хорих ангиас хуяг харуулууд нь өөрсдөө

бараг унаагаар шахуу авч явж эмчилгээнд оруулах гэж явдаг. Тэгээд тэндээ аягүй их зардал хэрэгтэй болдог. Тэгээд эдгэрэл их муутай. Яагаад гэхээр тэр чинь төсвөөс шийдсэн зардал байхгүй учраас. Ингээд нэг ийм завсар зааг үүссэн байдаг юм билээ.

Тэгэхээр энэ дээр жишээлбэл “үндэсний тогтолцоо” гэж байгаа зүйл дээрээ мэдээж Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, хажуугаас нь маш сайн судлаачид орсон энэ тогтолцоог бий болгох ёстой байх.

Яах вэ, энэ бол тогтоол гарсны дараа Засгийн газар дээр яригдах байх. Тэр 6 дээр байгаа зүйл дээр олон жил хүмүүс энэ дээр их болгоомжилж ярьж явсан. Энэ чиглэлийн зүйлийг хориглох гээд, соён гэгээрүүлэх гэхээр сурталчилгаа болдог гэсэн ийм хандлага маш их яваад байдаг байсан.

Эртээр хаалттай хурал дээр ярьсан тоо баримтыг энд хэлж болохгүй байх. Тийм ээ. Зүгээр ер нь агуулгаар нь хэлэхэд яг энэ төрлийн гэмт хэрэг тоог нь хэлэхгүй ч гэсэн тархацын бодит нөлөөлөл нь тэд дахин том байдаг гэсэн нэг том тоо хэлээд байгаа.

Тэгэхээр энэ бол их аймшигтай тоо байгаа учраас яг үүнийг тийм системтэй зөв хийхгүй бол манайхан чинь аягүй олон төрлийн л хөтөлбөр боловсруулаад л, тэгээд л тэр нь үр ашиг багатай өнгөрдөг. Мэдээж зөвхөн Боловсролын яамнаас гадна үүнийг олон талаас нь авч үзэх ёстой байх.

7 дээр байгаа тэр устгалтай холбоотой зүйл дээр дрон ашиглах. Технологи гэдэг нь энэ чиглэлийн зүйл дээр нээлттэйг нь хэлж байна гэж ойлгож байна. Зөв үү? Байнгын хорооны дарга аа. Тийм. Дроноор устгах боломжтой юм байна лээ шүү дээ. Олон улсад дроныг нь яг тодорхой програмчлаад ургамлуудын таньдаг “AI” суурилуулаад хийдэг гэсэн.

Тэгэхээр зүгээр гол санаа нь ажлын хэсэгт ч юм уу хэлэхэд нэг тогтоол гардаг. Тэгээд энэ оны дөрөвдүгээр улиралдаа Засгийн газар багтааж тайлбарлана гэж байдаг. Тэгж байтал чинь 6 сар, 7 сар, наадам маадам гээд л намар бахь байдгаараа байж байх вий дээ.

Маш хурдтайгаар энэ дээр ажиллагаа аваад явуулаад, хөтөлбөр эд нараа гаргаад яваасай л гэж хүсэж байна. Тэгээд энэ л зүйлийг хэлье дээ. Асуултгүй юм байна.

Г.Тэмүүлэн: С.Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Үг хэллээ. Ж.Энхбаяр гишүүн.

Ж.Энхбаяр: Тогтоолтой холбоотойгоор Улсын Их Хуралд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн аюулгүй байдлын

гадаад, дотоод орчинтой холбоотой хийсэн мэдээллийг гэж оруулбал их чухал. Зөвхөн Байнгын хороон дээр ярьсан асуулт биш гэж. Нэг.

Нэгдүгээрт, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Хоёрдугаарт, үндэсний стратеги боловсруулж танилцуулах. Ийм хоёр заалттай л гаргавал яасан юм бэ гэсэн санал байна. Бусад нь энэ үндэсний стратеги дотор, хууль эрх зүйн орчин дотор орох асуудлууд байна. Агуулгын хувьд. Хоёр заалттай л.

- ▶ Эрх зүйн орчныг боловсронгуй болгоод аваад ир.
- ▶ Үндэсний стратегиа аваад ир.
- ▶ Хугацааг хоёрдугаар улиралд багтааж танилцуул гэж.

Үндсэндээ эдний дээр бүх хуулийн хэрэгжилт, болж байгаа, болохгүй асуудлууд, олон зүйл тодорхой болсон. Ялангуяа ялын бодлоготой холбоотой чангатгах асуудал гээд олон зүйл байгаа. Бэхжүүлэх. Үндсэндээ боловсрогдсон юмнууд байгаа.

Тэгэхээр шинэ төсвийн хуулиар чинь 07 сарын 25-ны дотор Засгийн газар төсөв батлагдах, яамд санал өгч дуусах ёстой. Түүнээс өмнө Байнгын хороо эдний хууль эрх зүйн орчин болон шаардлагатай тэр төсвийн бодлогыг нь авч үзээд. Хоёрдугаар улиралдаа. Тэгээд төсөвтөө санал болгоод 3, 4 сар төсөв хэлэлцэхэд энэ бүр бодлого болоод хэрэгжээд, 01 сарын 01-нээс үйл ажиллагаа нь шилжих маягаар ингэж оруулбал.

Тэгэхээр энэ асуудлыг Хууль зүйн яам, Хар тамхитай тэмцэх газар 5 сар, 6 сар, 7 сарын 10-ны дотор оруулж ирж чадах уу гэдэг асуулт байна.

Энд үнэхээр улс төрийн хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, манлайлал зайлшгүй шаардана. Нөгөө талаасаа хууль сахиулах байгууллагуудын мэргэжлийн ур чадварын асуудал.

Бид энэ байгууллагыг бас л нэг юм сонсож байгаад л асуудал ер нь хүндрэх нь. Бид дамждаг орон боллоо. Одоо борлуулах сувагчлал эхэлж байна. Яаралтай урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй болохоо байлаа гээд энэ газрыг бид байгуулсан юм. Нэлээн томоохон хүч хэрэгсэлтэй байгуулсан.

Гэтэл бүх авч байгаа мэдээгээр харахад жил ирэх тутам хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоо тасралтгүй нэмэгдсэн байгаа юм.

Манай газрын өөрийн мэргэжлийн ажилтан, албан хаагчид өөрсдөө энэ асуудалд нэлээн гүнзгий хутгалдсан жишээнүүд хэд хэдэн удаа гарсан. Танилцуулагдаж байсан.

Тэгэхээр асуудал яг юундаа байна. Даргаас нь асуумаар байна. Яагаад мэргэшсэн байгууллага бий болоод, хамрах хүрээ нь тодорхой. Үндсэндээ цөөхөн. Улаанбаатар хотын гол газар л тавьж байгаа хяналтууд шүү дээ. Яагаад энэ гэмт хэрэг нэмэгдээд байгаа юм? Юунаас болж байна гэж та нар үзэж байгаа юм? Үүний санаа бодлыг нэг сонсмоор байна. Ийм санал байна.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр гишүүнд баярлалаа. Ж.Энхбаяр гишүүний асуултад хариулъя. 5 номер хариулах уу. Тийм ээ. Тэгье. П.Сандагсүрэн хурандаа. Дараа нь сайд шаардлагатай та нэмээд тайлбар, мэдээлэл өгөөрэй. 5 номер.

П.Сандагсүрэн: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын дарга, цагдаагийн хурандаа П.Сандагсүрэн байна.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг жил болгон өсөж байгаа. Тэгээд сая ерөнхийдөө дамжин өнгөрөгч орон, цаашлаад худалдан борлуулах, цаашлаад үйлдвэрлэгч орон руу шилжихэд бэлэн болсон байна гээд.

Тэгээд нийт үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 70 хувь нь дотоодын нийлүүлэлт буюу ургамлын гаралтай каннабисийн ургамалтай холбоотой гэмт хэрэг эзэлж байгаа.

30 хувь нь гадаад нийлүүлэлт буюу синтетик төрлийн бодис орж ирж байгаа гэмт хэргүүд эзэлж байна.

Энэ гэмт хэргийн гаралт яагаад буурахгүй нэмэгдээд байна вэ гэхээр бид бүхэн нэгдүгээрт гаднаас орж ирж байгаа нийлүүлэлт дээр бид бүхний тавих хяналт, энэ чиглэл рүү орж байгаа хууль, эрх зүйн орчин дутмаг байна.

2002 онд Мансууруулах бодисын хууль бус хэрэглэлтэй тэмцэх тухай хууль батлагдсан. Шинэчилсэн найруулга явж байна. Дээр нь бид бүхэн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд урьдчилан сэргийлэх олон нийтийн хамтын ажиллагааг маш сайн. Иргэд, хүүхэд залуучууд энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг таниулах чиглэлийн ажлуудыг маш сайн бид хийх. Тэгээд уялдаа холбоогоо маш сайн сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

Дээр нь ялын бодлого гээд ерөнхийдөө. Нийт үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 57. Одоо бол 204 хүн яг ял эдэлсэн байж байна. Үүний 57.7 хувь нь давтан гэмт хэрэг үйлдэгдсэн байж байгаа.

Тэгэхээр ялын бодлого дээр бид бүхэн анхаарах хэрэгцээ шаардлагатай байна гэж харж байгаа.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр гишүүний бусад асуултууд дээр хэн хариулах вэ? Л.Нямгэрэл дарга. 4 номер.

Л.Нямгэрэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл байна. Ж.Энхбаяр сайдын асуултад хариулъя.

Байнгын хорооны тогтоолын стратегийг боловсруулах ажлыг өнөөдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Д.Ариунболд даргатай өглөө Үндэсний хорооны хурал хуралдуулаад энэ дээр энэ асуудлыг ярьсан.

Хуулийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хяналтад тавих, эргэлтэд хяналт тавих тухай хуулийг оруулаад ирж болох байх. Хамгийн гол нь энэ стратеги боловсруулах ажил тодорхой хугацаа шаардсан ажил. Ялангуяа, бидэнд нэлээн сайн судалгаа зайлшгүй шаардлагатай. Ялангуяа, 2022 оноос хойш хэрэглэгчдийн дунд судалгаа огт хийгээгүй байгаа. 2022 оны судалгаа маань ч гэсэн яг тухайн үед судалгаа хийгдэж байх жил дамнаж байх хугацаанд ковидын нөхцөл байдалтай байсан учраас бид нөхцөл байдлыг яг бодитойгоор гаргаж ирсэн гэдэгтэйгээ бас санал нийлэхгүй байгаа.

Ер нь хэрэглэгчид рүү чиглэсэн ажил туйлын чухал учраас, бидэнд судалгаа хийх зайлшгүй шаардлагатай учраас одоо яг энэ цаг хугацаанд Ж.Энхбаяр гишүүний хэлсэн хугацаанд бид оруулж ирж амжихгүй. Тийм. Төсөв байхгүй.

Г.Тэмүүлэн: О.Алтангэрэл сайд нэмж хариулъя. О.Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Ийм юм аа, Ж.Энхбаяр сайд аа.

Манай дээр ер нь нэлээд эртнээс хийсэн манай Б.Энхбаяр сайдыг байх үеэс хийсэн хуулийн бэлэн төсөл байгаа юм.

Тэгээд бид юу гэж харж байна вэ гэхээр үүнийг гүйцээгээд оруулаад, яг одоогийн байдлаар явуулчхаж болно. Тэгэнгүүт манай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос сая өнгөрсөн. Тэр чинь 3 сард байх аа. Хэлэлцүүлэг хийдэг чинь. Хэлэлцүүлэг хийгээд, анхаарал тавиад асуудлыг нэлээн юм болгосон. Одоо дахиад тогтоол гарах гэж байгаа учраас бид дахиад харъя гээд байгаа юм. Энэ асуудлаа. Илүү сайн болгоё гээд.

Өнөөдөр өглөө. Сая Л.Нямгэрэл дарга хэллээ. Хурал хийгээд бид асуудлуудаа ярьсан юм.

Тэгэхээр бид нэгэнт Улсын Их Хурлын тогтоол гараад, энэ тогтоолынхоо 1 дүгээр зүйлээр нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж, ийм ийм учраас хууль тогтоомжийг шинэчлэх нэмэлт өөрчлөх тухай саналыг шуурхай боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж.

Ингэсэн учраас аль болохоор бид хурдан хугацаанд энэ асуудлаа оруулна.

Өнөөдөр энэ тогтоолын төсөл маань яваад Улсын Их Хурлаар батлагдаад гарвал бид ерөөсөө намрыг хүлээлгүйгээр. Яагаад гэвэл бид цаг үеийн шинжтэй зөндөө олон асуудал байгаа. Тэгээд ер нь Байнгын хорооноос энэ асуудалд анхаарал хандуулаад, мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс анхаарал хандуулаад энэ асуудлыг бүр Их Хурлын түвшинд авч хэлэлцэж байгаад бидний хувьд баяртай байгаа.

Тэгэхээр одоо бол бэлэн болсон төсөл байгаа. Энэ хүрээндээ бид хурдан шуурхай ажиллаад аль болохоор хурдан өргөн барих энэ асуудлаа бид зохион байгуулна.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр гишүүн нэмж тодруулъя.

Ж.Энхбаяр: Тийм. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол биш Монгол Улсын Их Хурлын тогтоол гэдгээр оруулмаар байгаа юм. Тийм.

Нэгэнт Аюулгүйн зөвлөл дээр Ерөнхийлөгч өөрөө гадаад, дотоод аюулгүй байдлын үнэлгээгээ танилцууллаа шүү дээ. Хар тамхитай тэмцэх асуудал. Нөхцөл байдал хүндэрлээ. Их Хурал шийдвэр гаргаж, засаг ажлаа хий гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр тэнд холбогдож бид манай Байнгын хороо энэ асуудлыг анхааралдаа аваад Их Хурлын тогтоолын төсөл болгож өгөөд, Их Хурлын тогтоолоор Засгийн газарт нь чиглэл өгөөд ингээд нэг мөр шийдвэл яасан юм. Тийм.

Өдөөгдсөн асуудал нь тэндээс байхгүй юу. Тэгвэл илүү эрх зүйн хувьд буюу бодлогын хувьд Хууль зүйн яаманд их бодитой дэмжлэг. Төсөв хөрөнгө дээр ч гэсэн зохион байгуулалтын хувьд сайн дэмжлэг болох болов уу.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр гишүүн санал хэллээ.

Тэгэхээр цаг хугацаа алдахгүйн үүднээс. Дахиад нөгөө хууль тогтоомжийнхоо хуулиараа гишүүд хууль санаачилна гээд, Улсын Их Хурал руу оруулна гээд явдаг. Тэгээд 6, 7 сар болдог. Хугацаа алдах л асуудал болох байх.

Тэгэхээр бид цаг хугацаатай асуудал. Хууль эрх зүйн орчин нь өөрөө 2002 оны хууль шаардлага хангахгүй байгаа, хангалтгүй байгаа учраас үүнийг шуурхай тогтоолоо энэ долоо хоногтоо би баталж байх нь зөв байх гэж бодож байна.

Тэгээд Хууль зүйн яам энэ тогтоолын хүрээнд хуулиа шуурхай оруулж ирээд. Магадгүй бид хуулийг хэн ч оруулж ирж болно гэж харж байгаа. Энэ хаврынхаа чуулгандаа багтаад та хэд одоогийн байгаа боловсруулсан түвшиндээ оруулж ирээд. Магадгүй үндэснийхээ стратегиа боловсруулаад түүнийхээ дараа дахиад шаардлагатай хууль, эрх зүйн орчны өөрчлөлт байвал намар ч гэсэн 9, 10 сард оруулж ирээд явах нь зүйтэй байх.

Бид энэ дээр цаг хугацаа алдахгүй, зохион байгуулалт алдахгүйгээр шуурхай явах нь зөв болов уу л гэсэн ийм саналтай байгаа гэж хэлье.

О.Алтангэрэл сайд сая микрофон дээр байсан. Сая хариулт хэлээд таны нэр утсан байна. Та асуулт, үгээ.

О.Алтангэрэл: Би үг хэлэх гэсэн юм.

Өнөөдрийн энэ тогтоол дээр бусад яамдад нэлээн хариуцлагажуулах хэрэгтэй байгаа юм. Тухайлах юм бол Эрүүл мэндийн яам энэ асуудалд маш чухал үүрэгтэй шүү дээ. Одоо энэ сэргээн засах төвийн үйл ажиллагааг зохицуулсан зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах асуудлыг Эрүүл мэндийн яам хариуцаж хийх ёстой.

Тэгээд бид хар тамхитай тэмцэж байгаа, энэ сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэж байгаа үйл ажиллагааны хүрээнд жишээлбэл тэр мансууруулах зорилгоор хэрэглээд байгаа тэр эмийн хэрэглээтэй холбоотой бичиг цаасыг Эрүүл мэндийн яам руу өгдөг. Тэгээд радиологийн төв энэ байгууллагуудтай нь хамтарч ажилладаг гээд чухал ажил байгаа.

Тэгээд дээрээс нь манай Хүнс, хөдөө аж ахуйн яамны оролцоо чухал байгаа.

Бид нөгөө устгалынхаа чиглэлээр ажиллахад энэ каннабис, олсны төрлийн ургамлуудын устгалыг хийхэд энэ чинь өнжөөсөн, атаршсан газар, өвөлжөө бууцанд их ургаад байгаа. Тэгээд энэ дээр хамтарч ажиллах шаардлагатай байгаа гээд ийм асуудлууд байгаа.

Тэгээд өнөөдөр яг Байнгын хорооны түвшинд энэ асуудлыг ингэж ач холбогдол өгөөд нэлээд хэд удаа ярилцаад явж байгаад баяртай байна. Тэгээд манай цагдаагийн байгууллагын хар тамхитай тэмцэх нэгжийн үйл ажиллагаатай Байнгын хорооны гишүүд маань даруй танилцаасай.

Үүгээр зогсохгүй энэ сэргээн засах төвтэй холбоотой. Одоо манай улсад чинь яг албан ёсоор донтогсдыг, нэн ялангуяа мансууруулах бодисын хамааралтай нөхдүүдийг эмчлэх асуудал туйлын тулгамдсан асуудал байна шүү дээ.

Тэгээд би нэг хүсэлт тавиад байгаа. Байнгын хорооныхоо гишүүдэд. Одоо энэ төсөв хэлэлцэх үеэр манай энэ архины сангийн царцаачихсан мөнгө байгаа. Энэ мөнгийг авч Төв аймгийн Баян суманд байгаа Мааньтын албадан эмчилгээг хэдүүлээ сэргээн засах чиглэлийн эмнэлэг барих ажилд зарцуулмаар байна.

Ер нь гэмт хэрэгтэй тэмцэх, дараа нь аддиктолог_[донтолт]-ийн чиглэлээр өвчтэй байгаа хүмүүсээ сэргээн засах, урьдчилан сэргийлэх бүхий л түвшинд ажилламаар байна.

Тэгээд Хууль зүй, дотоод хэргийн яамны хувьд Байнгын хорооны тогтоол, энд яригдсан зүйлүүдийг хэрэгжүүлж ажиллахад бэлэн, талархаж хүлээж авч байгаа гэдгээ илэрхийлье.

Г.Тэмүүлэн: О.Алтангэрэл сайдад баярлалаа. Үг хэллээ. Л.Энхнасан дарга асуулт асууж, үг хэлнэ.

Л.Энхнасан: Баярлалаа.

Энэ асуудлыг бид Байнгын хороонд өмнө ярьсан. Тэгээд тогтоолд өгсөн хоёр саналууд маань орсон байгаад баяртай байна.

Нэгдүгээрт, Эрүүл мэндийн яамтай холбоотой мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бүхий хэрэглэсэн, түүнээс хамааралтай этгээдэд мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх гээд эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж үйлчилгээний тогтолцоог бий болгох гээд.

Энэ бол өнөөдөр сая гишүүд бүгд ер нь ихэнх нь ярьж байна. Хамгийн чухал асуудал байгаа.

Харин би нэг юм асуух гээд байна. Одоо хэрэглэгч бол Монгол Улсын хуулийн дагуу эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээж байгаа. Хэрвээ эмчилгээ ер нь нөхөн сэргээх арга хэмжээнд хамрагдах бол одоо миний ойлгож байгаагаар шүүх шинжээчийн дүгнэлтийг үндэслэдэг гэж ойлгож байгаа. Зөв үү? Энд нэг жоохон мэдээлэл өгөөч.

Ер нь мансууруулах бодис, эм бол бүр нарийн болсон байгаа. Тэгээд илүү эмийн төрлийн мансууруулах хэрэглээ нэмэгдэж байгаа учраас энэ дээр Эрүүл мэндийн яам анхаарч ажил аа. Манай Байнгын хороо энэ асуудлыг тусгайлан авч ярилцах нь зүйтэй юм байна. Энэ дээр хамтарч ажиллахад бэлэн байна.

Г.Тэмүүлэн: Л.Энхнасан гишүүний асуусан асуултад хариулъя. Л.Нямгэрэл дарга. 4 номер.

Л.Нямгэрэл: Гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын соёрхон баталж нэгдэж орсон 4 конвенц байдаг. Хар тамхитай холбоотой. Тэгээд конвенцод нэгдэж орсон улсын хувьд дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх ёстой. Үүний хүрээнд Монгол Улсад өнөөдөр хэрэглэсэн үйлдлээр буюу хэрэглэгч өнөөдөр эрүүгийн хариуцлага хүлээхгүй. Зөвхөн Зөрчлийн тухай хуулиар Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээгээд явж байгаа.

Бусад Эрүүгийн хуульд байгаа бусад үйлдлээр эрүүгийн хариуцлага хүлээгээд, ингээд Эрүүгийн хуульд заасан ял шийтгэлээ хүлээгээд явж байгаа.

Таны асуултад нэмэлт болгоод хариулахад ер нь хэрэглэгчийг дэлхий нийтээр “донтогч” буюу “өвчтөн”, “донтох эмгэгтэй өвчтөн” гэж үзэж байгаа учраас ер нь сүүлийн жилүүдэд олон улсын туршлагаар илүү хэрэглэгчдийг хэрэглээнээс гаргах, эмчлэх, нийгэмшүүлэх, эрүүл мэнд, нийгмийн тусламж үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох ажил руу дэлхий нийтээр хандсан учраас бид ч гэсэн ер нь үндэсний хороон дээр төлөвлөгөөндөө энэ ажлуудыг илүү түлхүү тусгаад явж байгаа.

Нөгөө талдаа хууль бус эргэлттэй тэмцэх асуудал дээр эрэлтийг бууруулах ажил үндсэндээ дэлхий нийтийн яг одоогийн хийгдээд явж байгаа ажил. Бас тэр хүрээндээ ч гэсэн хууль сахиулах байгууллага, цагдаагийн байгууллагын эрэлт бууруулах ажил руу ч нэлээн хандаад ажиллаж байгаа гэдгийг давхар хэлье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Д.Ганбат гишүүн асуулт асууж үг хэлнэ.

Д.Ганбат: Ер нь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо санаа зовоод энэ талаар тогтоол гаргаж байгаад талархалтай хандаж байна.

Монгол Улсын хувьд хуучин тээвэрлэгч орон гээд л яригддаг байсан. Одоо тээвэрлэгч, хэрэглэгч ийм орон болсон байгаа байхгүй юу. Аягүй бол үйлдвэрлэгч болох юм уу, яах юм. Тэрийг нь мэдэхгүй байна.

Ингэхээр энэ дээр бид санаа зовох ёстой асуудлын нэг мөн үү гэвэл мөн болчихоод байна.

Гэхдээ бид бүхэн урьдчилж анхаарч энэ юмаа. Ер нь юу болчихлоо шүү дээ. Тэгээд хаалттай ярилцдаг бол буруу юм байна. Бид байгаа юмыг ил тод ярьж байх шаардлагатай байдаг.

Одоо хэвлэлээр гарч байгаа, сошиалаар явж байгаа юм энэ тэрийг хараад байхад тэр гар хөлөө авхуулж байгаа ийм бага насны хүүхдүүд ч байна, олон гэр бүлүүд үүнээс болж хохирч байгаа юм байна. Бид хуулиа ч гэсэн авч үзэх шаардлагатай гэж үзэж байна.

Тэгээд Засгийн газар маань одоо яг ямар ажил хийгээд байна аа? Бүр санаа зовоод Байнгын хороо маань ийм тогтоол хийж байна. Гаргаж байна. Гэтэл Засгийн газар маань ямар ажил хийгээд энэ дээр юу хийгээд явж байна? Үүнийг нэг асуучихмаар байгаа байхгүй юу.

Засгийн газар, Байнгын хороо хоёр хамтраад ажиллаж байвал, Улсын Их Хурал ажиллаж байвал нэн сайн. Бид байгаа юмыг нь байхгүй юм шиг ингээд тоохгүй өнгөрөөд байж болохгүй л дээ.

Нөгөө талаар өнөөдөр тэр шийтгэл авсан хүмүүс маань ямар байдлаар шийтгэгдээд байна аа? Хэрэглэгчийн шийтгээд байна уу? Тэр худалдан борлуулдаг хүмүүс нь ял аваад ингээд явчхаад байна уу? Нөхцөл байдал яг ямар байна вэ?

Нөгөө талаар сүүлийн үед маш хямдхан тийм хар тамхи, мансуурах бодисын төрлийн юм маш их орж ирж байна гэж байгаа. Энэ одоо бүр тийм хямдарчихсан байгаа юу? Ерөөсөө энэ чинь нийгмийн ядуурал, ажилгүйдэл энэ бүх юман дээр чинь л энэ бүх мансуурах юм чинь л ихсэж байгаа шүү дээ. Манай залуучууд үнэхээр ирээдүй нь бүрхэг байна л даа. Энэ авлига, хээл хахууль, энэ бүх юм чинь бүр бүрхчихсэн. Энэ ядуурал нь ч гэсэн жилээс жилд ихэссэн. Авлига бас ихэсчихсэн ийм байхаар чинь иргэд чинь юундаа ч итгэж найдах вэ.

Тэгээд хуулийн хэрэгжилт хүн болгонд харилцан адилгүй тусдаг. Ийм байгаа талаар Та бүхэн судалгаа энэ тэр юм хум байна уу? Энэ дээр бид өнгөцхөн ингээд л тогтоол гаргаад л явчхаж байгаа юм. Яг ул үндсээр нь энэ асуудал дээр ийм шийдвэр гаргаж чадахгүй байгаа шүү.

Тэгэхээр дараа дараагийнхаа юман дээр Засгийн газартаа, Улсын Их Хурлаа. Улсын Их Хурлын тогтоол бол бүр үндсэн юмаараа гаргаж байх хэрэгтэй гэж бодож байна. Одоохондоо бид энэ тогтоолоо өнөөдрийн хувьд ингээд батлаад явах нь зөв байх л гэж бодож байна. Тийм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Д.Ганбат гишүүнд баярлалаа. Тэгье. Манай Хууль зүйн яамныхан хариулаарай.

Засгийн газар, Улсын Их Хурал хоёр хамтарч ажиллаж байгаа. Энэ дээр. Бид Хууль зүйн яамнаас гол үндсэн санал болоод, энэ мансууруулах бодис, сэтгэц нөлөөт энэ бодистой тэмцэхтэй холбоотойгоор, урьдчилан сэргийлэхтэй

холбоотойгоор учирч байгаа хүндрэл бэрхшээл энэ асуудлуудыг бүгдийг нь цогц байдлаар нэг талдаа шийдэх. Яг энэ ажил дээр гардан тулаанд орж энэ асуудал дээр нэлээн ачааг нь үүрч байгаа хүмүүст тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэх үүднээс өнөөдрийн тогтоолыг үндсэндээ холбогдох мэргэжлийн байгууллагуудын санал, санаа оноог авч байж энэ тогтоол боловсруулагдсан байгаа гэдгийг хэлэх байна.

Энэ асуудал маань нэгдүгээрт бид яг бодлогын түвшинд энэ хоёр асуудлыг л гаргаж ирж тавиад байгаа юм.

Нэгдүгээрт, хууль, эрх зүйн орчин өөрөө шаардлага хангахгүй байгаа учраас үүнийгээ шинэчилсэн найруулгаар шинэчилж найруулж оруулж ирье.

Тэгээд тэр эрүү, зөрчлийнх нь хуулийн холбоотой асуудлууд байдаг юм бол тэрийг нь та хэд судлаад холбогдох хууль тогтоомжийнхоо хүрээнд оруулж ирнэ биз гэдэг асуудал байж байгаа юм.

Хоёр дахь үндсэн асуудал бол үндсэндээ бид эндээс гаргаж байгаа гол чиглэл өгч, даалгавар өгч, хугацаатай даалгавар өгч байгаа асуудал маань одоо үндсэндээ бид энэ асуудлыг шийдэхэд, хар тамхитай тэмцэхэд энэ үндэсний стратеги, төлөвлөлт гэдэг зүйлийг нэг боловсруулж оруулж ирээч. Үүнийгээ хийхийн тулд судалгаан дээр суурилагч гэдэг асуудлыг тавиад байгаа юм.

Тэгэхээр судалгаа гэдэг зүйлийг би бүр энд онцолж хэлэх гээд байгаа зүйл маань бид яг энэ хэрэглэгчтэй холбоотой, донтогч нартай холбоотой суурь судалгаа. Энэ нэг талдаа хууль бус зах зээл, хууль бус бизнес. Хамгийн том зах зээл, хамгийн том бизнес болчихоод байгаа. Дэлхий дээр.

Тэгэхээр энэ асуудлыг бид яахын тулд суурь нөхцөл байдал, өнөөгийнх нь нөхцөл байдлыг нэгдүгээрт харах хэрэгтэй байна. Ххэрэглэгчийнхээ нарийвчилсан тандалт, судалгааг хийх ёстой байна гээд байгаа.

Энэ дээр манай Хууль зүйн яам яг энэ үндэсний стратеги, төлөвлөлтөө гаргахын тулд “хэрэглэгч”, “донтогч” нарынхаа тоог бодитоор нэгдүгээрт гаргах хэрэгтэй байна. 2021 онд буюу одоогоос 4 жилийн өмнө та нар мэргэжлийн судалгааны судалгааны байгууллагаар үүнийг хийлгэсэн байна. Үүнийгээ шинэчлээд, үүн дээрээс шинэчилсэн тоо баримт дээр үндэслээд бодлогоо гаргая. Хэрэглээнийх нь давтамжууд нь ямар байгаа юм. Тэр нөхдүүд дээр, хэрэглэгч нар дээр, донтогч нар дээр. Дээрээс нь хэрэглэгч нарын тэр насны ангилал нь ямар байгаа юм. Насныхаа ангиллаас хамаараад магадгүй ямар төрлийн бодисыг эмийг, хэрэглээд байна гэдэг асуудлыг бүр нарийвчилж гаргах хэрэгтэй байгаа юм.

Тэр 10 жилийн хүүхдүүд дээр байна уу, их дээд сургуулийн хүүхдүүд дээр байна уу, 35 хүртэл насны залуучууд дээр байна уу.

Ингээд эрүүгийн хэргээр шийтгэгдсэн, ял шийтгэл авсан нөхдүүд яг ямар зүйлийг хэрэглээд байна уу гэдэг асуудлуудыг бүр нарийвчилж гаргах зайлшгүй шаардлагатай байна гэж харж байгаа.

Бид нарын гол анхаарах ёстой асуудал бол үндсэндээ бид хар тамхи буюу энэ сэтгэцэд нөлөөт бодис гэдэг гадаадаас орж ирж байгаа эргэлттэй холбоотой асуудлаас гадна дотоод эргэлтийг зайлшгүй контролдоо авч, хяналтдаа авч анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

Яагаад вэ гэхээр мэргэжлийн хүмүүсийн өгч байгаа судалгаагаар нийт энэ эргэлт, хэрэглээний чинь 70 хувь нь дотоодоосоо байна буюу хууль ёсны бизнес болчихоод байгаа энэ эмийн хэрэглээ. Энэ дотроо бид бүхний ярьж байгаа манай мэргэжлийн байгууллагууд бид нарт хэлсэн мэдээллээр трамадол, морфин ч гэдэг юм уу энэ эмүүдийг жортой, жоргүйгээр авч болдог. Тийм ээ. Эргээд бид нэг талдаа хууль ёсны энэ эргэлттэй, хэрэглээтэй асуудлыг Эрүүгийн хуулийн гадуур явж ял завшдаг. Тийм ээ. Ингээд ямар нэг хариуцлага хүлээдэггүй асуудлыг цогц шийдэх хэрэгтэй байна гэдэг асуудал байгаа юм.

Тэгэхээр энэ жагсаалтыг дотооддоо зайлшгүй гаргадаг байх хэрэгтэй байна. Шинэчилдэг байх хэрэгтэй байна. Олон улсын тэр НҮБ-ын конвенцынх нь жагсаалтад нь шинэчилж бүртгүүлж ингээд ял завшдаг. Энэ асуудлууд дээр ч гэсэн хатуу хариуцлага хяналттай байх энэ асуудал чухал байна гэсэн энэ хоёр гол зүйлийг оруулж өгсөн байгаа гэдгийг онцолж хэлэх байна.

Тэгээд Хууль зүйн яам болоод манай Байнгын хороо энэ дээр хамтарч ажиллаж энэ тогтоолын төслийг гаргаж ирж байгаа. Цаашлаад улс төрийн манлайллын манай Байнгын хороод болоод манай гишүүд маань бид бүрэн дүүрэн үзүүлнэ гэдэг итгэлтэй байгаа.

Ингээд цаашид бид ирэх долоо хоногт холбогдох газар дээр очиж танилцаад, Байнгын хорооноос холбогдох ажлын хэсгийг гаргаад, саяын тэр хууль тогтоомж болон бодлоготой холбоотой үндэсний стратеги, төлөвлөлттэй холбоотой асуудлууд дээр ч гэсэн бид бодлогын санал, санаачилга гаргаж ажиллах, манлайллын үзүүлэх чиглэлээр бүрэн дүүрэн ажиллана гэдгийг энд хэлэх байна.

Нэмээд Хууль зүйн яамнаас хариулъя. Л.Нямгэрэл дарга. 4 номер.

Л.Нямгэрэл: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар энэ хар тамхитай холбоотой асуудал салбар дундын үйл ажиллагааг уялдуулж зохицуулах үүрэг бүхий Үндэсний хороо ажиллах ёстой.

Тэгээд Үндэсний хороо Засгийн газрын тогтоолоор байгуулагдаад Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан Үндэсний хороо ажиллаж байгаа. Үндэсний хорооны ажлын албыг мөн манай ажлын алба гүйцэтгэдэг.

Бид жил болгон Үндэсний хороо хуралдаж төлөвлөгөөгөө батлуулдаг. Тэгээд 2017 онд хоёр дахь удаагаа бид “Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх үндэсний хөтөлбөр” гэдгийг батлуулаад тэгээд 5 жил хэрэгжүүлээд дунд хугацааны хөтөлбөр дууссан. Энэ хугацаанд бид нийтдээ 7 орчим тэрбум төгрөгийг хууль сахиулах болон шүүх шинжилгээний байгууллага, гаалийн байгууллагуудын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг сайжруулах ажилд зарцуулаад 2022 онд үндэсний хөтөлбөр хэрэгжээд дууссан.

Тэгээд одоо Хууль зүй, дотоод хэргийн сайдын өөрийнх нь багцад байдаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас бид энэ хар тамхитай тэмцэх үйл ажиллагаа, үндсэн чиг үүрэг бүхий байгууллагуудын зарим нэг үйл хэрэгцээ шаардлагатай техник, тоног төхөөрөмж, мөн энэ алба хаагчдыг сургах, чадавхжуулах ажлыг төлөвлөөд хэрэгжүүлээд явж байгаа.

Ер нь олон улсын байгууллагуудын туршлагыг бид байнга л үзэж харж судалж байгаа. Тэгээд Нэгдсэн Үндэстний Байгууллагын хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба, мөн хяналтын хороо гэж байдаг. Эдгээр байгууллагуудаас өгч байгаа зөвлөмжүүдийг бид байнга хэрэгжүүлэх тал дээр төлөвлөгөөгөө гол нь энэ ажлууд дээр. Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмж гэх мэт байгууллагуудын зөвлөмжийг хэрэгжүүлэх тал дээр гол нь төлөвлөж ажилладаг. Гэхдээ үндсэндээ төсөв, санхүүгийн хувьд бас хэцүү.

Ахиад дээрээс нь, ялангуяа энэ стратеги хэрвээ боловсруулаад гарах юм бол үүнийг дагаад яг энэ хуулиар чиг үүрэг хүлээсэн байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг нь, хилээр гаднаас орж ирж байгаа синтетик бодисыг нь гааль дээр илрүүлэх, дотоодын цагдаагийн байгууллага болон шүүх шинжилгээний байгууллагын шинжилгээний тоног төхөөрөмжийг сайжруулах тал дээр илүү анхаарал хандуулж төсөв, мөнгийг нь сайн тавиад өгөх боломж байх юм бол, зэрэгцүүлээд бид алба хаагчдаа нэлээн сайн чадавхжуулж сурах хэрэгтэй байна.

Гэхдээ бид санхүүжилт, төсвөөс үл хамааран энэ ажлыг тогтмол хийж байгаа гэдгийгээ хэлье. Хариулж дууслаа.

Г.Тэмүүлэн: Д.Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Ер нь би та бүхнийг ил тод байгаач ээ л гэж хэлэх гээд байгаа юм л даа. Засгийн газрыг. Одоо энэ хар тамхитай тэмцэж байгаа бүх хүмүүсийг, албыг тийм ээ. Одоо олон нийтийн байгууллагыг татах хэрэгтэй. Энэ ажилдаа. Тэгээд мэдээллээр сайн хангах хэрэгтэй. Тэгэхгүй бол айл гэр, хүүхэд, эх эцэг,

тухайн анги, хамт олон нь мэдэхгүй байна шүү дээ. Яг ямар хор хөнөөлтэй юм бэ гэдгийг нь. Тэрийг сайн сурталчлан таниулах хэрэгтэй байна.

Нөгөө талаараа энэ мансуурах, хар тамхи хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа хэдэн хувийг нь эзлээд байна вэ? Үүнтэй холбогдоод хэр хэмжээний олон хүмүүс шүүхээр ороод ялаа эдэлж байна вэ гэсэн ийм л зүйлийг асуугаад байгаа юм л даа би.

Г.Тэмүүлэн: Хэн хариулах вэ? П.Сандагсүрэн дарга уу? Тэгье. 5 номер.

П.Сандагсүрэн: Улсын хэмжээнд сүүлийн 8 жилийн хугацаанд 29 мянга 700 гэмт хэрэг бүртгэн шалгагдсан.

Үүний 1789 гэмт хэргийг нь хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг буюу нийт гэмт хэргийн 0.7 хувийг нь эзэлж байгаа. Сүүлийн 8 жил дээр.

Г.Тэмүүлэн: 6 номер нэмж хариулъя.

Б.Батзориг: Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа Б.Батзориг илтгэж байна.

Хариултад нэмээд тодруулаад хэлэхэд мөн төрийн байгууллагын зүгээс, цагдаагийн байгууллагын зүгээс энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ, мөн Засгийн газраас холбогдох ажил, арга хэмжээг зохион байгуулж байгаа.

Хамгийн гол нь бас нэг анхаарах зүйл бол хууль хууль сахиулах байгууллага, хуулийн байгууллагуудын нэг хэлээр нэгдмэл ойлголттойгоор энэ төрлийн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэх асуудал байгаа юм. Тухайлбал, энэ төрлийн гэмт хэрэг шалгагдаад, шийдвэрлэгдээд прокурор, шүүхэд шилжүүлсэн байхад шийдвэрлэгдэхгүй 3 жил, 4 жил болоод. Эхэндээ тухайн эрүүгийн хэргүүд нь нэг холбогдогчтой, 2 холбогдогчтой байсан уу, үгүй байвал сүүлдээ шүүхээс хэрэг нь буцах, прокуророос буцах, мөрдөн шалгах ажиллагаанд дахин гэмт хэрэг үйлдэх гээд. Тухайлбал, одоо 10 гаруй холбогдогчтой гээд хэргийн явц, байдал, холбогдогч өшөө нэмэгдэх.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмээд хариулчих. 6 номер нэмээд хариулъя.

Б.Батзориг: Шүүх дээр хэргийг эцэслэн шийдвэрлэхэд бас нэг бодлоготой байх хэрэгтэй байна. Мөн ялын хэмжээ нь 1-ээс 5 жил гэсэн байгаа. 1-ээс 5 жил. 20.7 дээр. Шүүхээс практикт ихэнх тохиолдолд 1 жил буюу хамгийн доод санкцыг өгч байгаа.

Энэ нь өөрөө энэ төрлийн гэмт хэрэгтэй төрийн зүгээс ялын бодлогын хэмжээнд оногдож байгаа ял шийтгэл нь үнэхээрийн нийцэж байна уу, үгүй юу гэдэг дээр бас анхаарч үзэх нь зүйтэй болов уу гэж үзэж байгаа. Яагаад гэвэл энэ төрлийн гэмт хэргүүд 80 гаруй хувь нь дахиад дахин давтан үйлдэгдээд байгаа. Энд л их анхаарах. Энэ төрлийн гэмт хэрэг дахиад цаашаагаа давтагдах, даамжрах ийм нөхцөл үүсэх шалтгаан. Бас анхаарах хэрэгтэй зүйл болов уу гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа Д.Ганбат гишүүн болсон уу? Тийм ээ.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Та үг хэлэх байсан уу, үгүй юу? Тэгье. Б.Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Сая цагдаагийн байгууллагын хариултаас буруу, зөрүү ойлголт гарчих вий гэдэг утгаар тодруулж хэлэх шаардлага үүсэж байна л даа.

Ял шийтгэлийн бодлого сул байгаагаас болоод хар тамхины хэрэг үүсээд байгаа гэж ярих аягүй буруу шүү. Ер нь шоронд хийгээд байя гэвэл шорон л бариад байна. Эмнэлэг барихгүй байгаа шүү дээ. Эмнэлгээ бариагүй байж шорон барина гэж яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр гэмт хэрэг буурчихдаг гэдэг юм хаа ч байхгүй.

Тийм учраас ялангуяа хар тамхитай тэмцэх бодлого дээр хатуу, зөөлөн аргыг хослуулж хэрэглэж байж үр дүнд хүрнэ. Харин зохион байгуулалттай нөхдийг ерөөсөө барихгүй байгаа шүү дээ. Өнгөрсөн хугацаанд нэг ч том зохион байгуулагч баригдаагүй. Дандаа хэрэглэсэн урлаг, соёлын оддыг урдаа гаргаж, том гэмт хэрэгтэн мэт харагдуулж, олон нийтийн бараг нэг бодлын сурталчилгаа ч болоод байдаг юм шиг байгаа юм. Тэр нь. Ингээд байгаа тал байгаа.

Тийм учраас одоо бид хар тамхитай тэмцэх бодлого дээр илүү ухаалаг бодлого барих ёстой. Энэ ухаалаг гэж ярьж байгаагийн чинь цаана ялыг нь нэмээд хориод байвал буурна гэсэн юм байхгүй шүү. Энэ гэмт явдал судлалаар ч нотлогддоггүй юм. Ер нь бол.

Тэр архитай дайн зарлаад юу болсон. Америк мафи буюу зохион байгуулалттай гэмт бүлэглэл архины хуурай хуулийн үр дүн, нөлөөгөөр гарч ирсэн юм шүү дээ. Мафи чинь анх. Зөвлөлт Холбоот Улс социалист дэглэм задрахад архийг нь хориглосон явдал нөлөөлсөн гэж бас үздэг юм шүү дээ. Энэ бол Америкийн тагнуулын байгууллагын репторд байдаг зүйл шүү дээ.

Өөрөөр хэлбэл архийг нь хориглосон чинь ард түмэн нь анх удаа социалист дэглэмтэй улсад жагсаал хийсэн байхгүй юу. Социалист дэглэмтэй улсад төр засгийнхаа эсрэг жагсаал хийж байсан гэхэд нөлөөлж байсан тийм зүйл байгаагүй. Архийг хориглосон чинь жагсаж байсан гэж байгаа шүү дээ.

Тэгээд ард иргэд төр засагтаа сэтгэл ханамжгүй ийм байдал тархаад, яг энэ агшинд нь ер нь энэ дэглэмийг нураах цаг нь болжээ гэдэг ийм репортыг тагнуулын байгууллага нь өгч байсан байдаг байхгүй юу.

Тийм учраас тэмцэх энэ асуудал өөрөө улс төр, эрх зүйн их урлаг, ухаан шаардсан ийм асуудал байгаа шүү гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Б.Энхбаяр гишүүнд. Гишүүд үг хэлж, санал хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалт явуулахаар байгаа. Хууль зүй, дотоод хэргийн яам болоод Цагдаагийн ерөнхий газрын удирдлагууд саяын гишүүдийн хэлсэн саналуудыг анхаарч үзээрэй.

Гишүүдээс гаргасан саналыг тогтоолд нэмж тусган “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулах байгаа. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалтыг явуулъя. /алх цохив/

Тогтоолын төсөл дэмжигдлээ. Гишүүдэд баярлалаа. Байнгын хорооны гишүүддээ болоод ажлын хэсгийнхэнд их баярлалаа. Тогтоол өнөөдрөөс хүчин төгөлдөр ингээд болж байгаа. Саяын тогтоол 70.6 хувиар дэмжигдсэн байна.

Санал хураалтад 17 гишүүн оролцсоноос 12 гишүүн дэмжсэн байна.

Байнгын хорооны гишүүд ирэх нэг дэх өдрийн 14.00 цагт Цагдаагийн ерөнхий газар дээр очиж газар дээр нь ажиллаж байгаа албан хаагчид болоод ажилчидтай уулзаж, энэ талаар Та бүхэндээ санал солилцож, цаашид авах арга хэмжээтэй холбоотой нөхцөл байдлын талаар газар дээр очиж танилцъя гэж байгаа.

Ингээд гишүүд маань дараа долоо хоногийн Цагдаагийн ерөнхий газар дээр ажиллах энэ юун дээр идэвхтэй оролцоорой гэдгийг хэлэх байна. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Байнгын хорон гишүүддээ баярлалаа.

Хэлэлцэх асуудал хэлэлцэж дууслаа. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 56 минут үргэлжилж, 15 цаг 05 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД